



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/23

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөхөгчин хэмээх могой жилийн сар шинийн баярт зориулсан үндэсний бөхийн барилдаан зохион байгуулахад зориулж 3,112,000 (гурван сая нэг зуун арван хоёр мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ